

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2023 ОНЫ 10 ДУГААР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2023.10.24

Байгууллагын гүйцэтгэсэн ажлын мэдээг долоо хоног бүр БОАЖЯам болон ЗДТГ-т руу цахимаар хүргүүлэн ажиллав.

8 иргэн, ААНэгж байгууллагын төслийн баримт бичигт БОНБЕҮнэлгээний дүгнэлт, 12 иргэн, ААНэгжүүдэд ус ашиглуулах дүгнэлт гаргаж хүргүүлэв.

Баян-Өлгий аймгийн ИТХ-ын 10 дугаар сарын 16-ны өдрийн ээлжит XVII хуралдаанаар тус аймгийн 2024-2028 онд хэрэгжүүлэх ан агнуурын менежментийн төлөвлөгөөг баталууллаа.

СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААР:

Байгаль орчны салбарын баруун бүсийн эмэгтэйчүүд Увс аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын "Ирвэстэй нутгийн ирээдүй" төслийн санхүүжилтээр "Олуулаа цуглаж, асуудлаа шийдвэрлье" баруун бүсийн байгаль орчны салбарын эмэгтэйчүүдийн уулзалтад оролцож. Байгаль орчны салбарын эмэгтэйчүүдийн оролцоо манлайллыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг идэвхжүүлэх, салбарын эмэгтэйчүүдийн ажил мэргэжлийн онцлогийг олон нийтэд сурталчлан таниулах зорилготой зохион байгуулагдлаа.



Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлын талаар хамтарсан удирдамж, уралдааны тухай сургуулиудад хог хаягдлын талаар сургалт зохион байгуулав. 6 сургуулийн 400-гаад сурагчид хамрагдсан.



"Цахим аймаг" бодлогын зөвлөмжийн хүрээнд Баян-Өлгий аймгийн төрийн албан хаагчдад цахим ур чадвар олгох сургалтад холбогдох албан хаагч нарыг оролцуулав.



Байгууллагын нийт албан хаагчдад Төрийн цахим үйлчилгээний Зохицуулалтын газрын Баян-Өлгий аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс "Төрийн цахим үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах" ажлын хүрээнд, цахим ур чадварын мэдлэг олгох сургалтыг зохион явуулав.



Мансруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчилд өсвөр насны хүүхэд, залуучуудыг холбогдохоос урьдчилан сэргийлэх, иргэд олон нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор Цагдаагийн ерөнхий газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Боловсролын ерөнхий газартай хамтран зохион явуулсан "Анзаар" арга хэмжээнд байгууллагын нийт албан хаагчдыг оролцуулав.



Улаанбаатар хотод Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны зохион байгуулж буй “Mining week -2023” уул уурхай долоо хоног зөвлөгөөнд ахлах мэргэжилтэн оролцов.



Төрийн албаны зөвлөлийн Баян-Өлгий аймаг дахь салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй, гүйцэтгэлийн удирдлага” сэдэвт сургалтад БОАЖГазрын албан хаагчид оролцуулав.
 Сургалт: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журмын өөрчлөлт болон хэрэгжүүлэхэд анхаарах зарим асуудлуудын сэдвийн хүрээнд зохион байгуулагдлаа.



БОАЖЯам, Хими, химийн технологийн хүрээлэн, Монгол улсад аюултай хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд аюултай хог хаягдлын шинжилгээний болон хүний нөөцийн чадавхыг сайжруулах" төслөөс зохион байгуулж байгаа "Монгол улс дахь Аюултай хог хаягдлын менежментийн өнөөгийн байдал ба гадаад улс орнуудын туршлага" сургалт, семинарт орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн, БОХУБ нарыг оролцуулав.



ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР:

Салбарын хяналтын газрын улсын ерөнхий байцаагчийн 2023 оны 04 сарын 25 өдрийн 01/14 дугаар “Байгаль орчин хяналтын чиглэлээр төлөвлөгөөт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Балбал тас ХХК, Баавгай хөндий ХХК, Өлгий ойл ШТС, Самал авто сервис, Аумин авто сервис зэрэг аж ахуйн нэгжүүдэд хугацаат өгсөн зөрчил арилгуулах албан шаардлагын биелэлтийг шалгаж “ИХ” эрсдэлтэй гарсан 4 объектыг “ДУНД” эрсдэлд бууруулж арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТАЛААР:

Дэлхийн өвд бүртгэлтэй Казах ард түмний өвөрмөц ёс заншил ,бүргэдээр ан хийх соёлын өвийг дэлхийд сурталчлан таниулсан аялал жуулчлалын хамгийн том арга хэмжээ болох “Бүргэдийн баяр-2023” эвент арга хэмжээ 24 дахь удаагаа 2023 оны 9 сарын 30, 10-р сарын 01- өдөр Баян-Өлгий аймгийн Буянт сумын 3-р багийн Шар нуурын “Хойлог” толгой хэмээх газарт батлагдсан хөтөлбөр ёсоор амжилттай зохион байгуулагдав.

Энэ жилийн “Бүргэдийн баяр”-ийн арга хэмжээнд 13 сумаас 160 гаруй бүргэдчид оролцлоо. Мөн Көкбар, Кыз хуар, Тенге илүү, Сур харваа зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулж, 1-р байр, 2-р байр, 3-р байрыг шалгаруулж, медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнав. Гадаадын 800 иргэн нийт 5000 гаруй үзэгчид оролцов.



ОЙН ТАЛААР:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг болон "Тэрбум мод" үндэсний мод тарих өдрийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын Газрын хамт олон "Ногоон төгөл" 3.5га цэцэрлэгт хүрээлэнд 108 ш бургас мод тарьж, Аав ээжүүддээ зориулан суврага босгов.



Баян - Өлгий аймгийн хэмжээнд тэрбум мод аяны хүрээнд намрын мод тарилтаар нийт 13,261 ширхэг мод тарив.



ХОГ ХАЯГДЛЫН ТАЛААР:

БОАЖГазар "Бүргэдийн баяр-2023" эвент арга хэмжээний ажлын хүрээнд Хог хаягдлын менежментийн асуудлыг хариуцан ард иргэдэд сурталчилгаа хийж, ахуйн хог хаягдлыг БОАЖГазрын БОХУБайцагч, Мэргэжилтэн, Байгаль хамгаалагчид зэрэг 8 хүний бүрэлдэхүүнтэй албан хаагчид оролцон иргэд болон аж ахуйн нэгжүүдэд шаардлага тавьж, 1,5 тонн гаруй хог хаягдлыг цэвэрлэв.




Төв талбайд Холивол хог Ангилвал баялаг дахибар цуглуулах арга хэмжээ зохион байгуулсан. Үүнд 400 барений шилийг “Алтай” тараг ХХКомпанид, хучин хувцасыг хэрэгтэй хүнд тарааж, 1 портер хуванцарыг “Казос” ХХКомпанид хүлээлгэж өгөв.



“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ БА ХОГ ХАЯГДЛЫН АСУУДАЛ” ОЛОН УЛСЫН УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДАВ.

Аялал жуулчлал, Хог хаягдлын салбарын өнөөгийн байдал, цаашид хийх асуудлуудыг танилцуулж, хэлэлцүүлэв. Уурзалтад Казахстан улсын төлөөллүүд Өлгий сумын 12 баг, 12 сум 1 тосгон, мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл, төрийн албан хаагчдаас бүрдсэн 200 гаруй хүн оролцлоо.



"ХОЛИВОЛ ХОГ, АНГИЛБАЛ БАЯЛАГ" УРАЛДААН АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.

Аймгийн төвийн аж ахуйн нэгж байгууллагуудын дунд хог хаягдлын тухай хуулийг сурталчлах, байгаль орчноо цэвэрлэх, дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг эргүүлэн ашиглах, дахин боловсруулах, ангилан ялгах сургах зорилгоор зохион байгуулагдсан "ХОЛИВОЛ ХОГ, АНГИЛБАЛ БАЯЛАГ" уралдаанд аж ахуйн нэгжүүд амжилттай оролцож

1-р байранд Өлгий сумын 6-р цэцэрлэг ,
2-р байранд Ерөнхий боловсролын 2-р сургууль
3-р байранд Баян-Өлгий аймгийн Соёл урлагийн газар ,
Тусгай байранд: Баян-Өлгий аймгийн Хүнс хөдөө аж, ахуйн газар,
Гэр бүл хүүхэд , залуучуудын хөгжлийн газар,
Ерөнхий боловсролын "Зайд" сургууль ,
Ерөнхий боловсролын "Бастама" сургууль,
Ерөнхий боловсролын 4-р сургуулиуд тус тус шагнагдлаа.



Өлгий сумын ЗДТГазрын 2023 оны 10- сарын 16 -ны 3/521 албан тоотыг бүх ААНэгж, байгууллагуудад Өлгий хотоос гарах, орох 6 чиглэлийн их цэвэрлэгээг зохион байгуулсан ба 67 байгууллага, 1536 албан хаагч оролцон их цэвэрлэгээ хийж нийт 25,6 тонн гаруй хог хаягдал цэвэрлэж нэгдсэн хогийн цэгт буулгаж ажиллав.



Цагааннуур тосгон: 2023.10.17ний өдөр аймгаас ирсэн анчинтай хамт золбин нохойнуудыг устгаж захирагчийн албаны сантехникч Сүхээ, манаач Жанайхан, нярав Өнербек нартай хамт ачиж хогий цэгт буулгаж ажиллав.



Тосгоны захирагчийн А/37 захирамжийн дагуу тосгоны хэмжээнд бүх нийтийн цэвэрлэгээ хийв.Цэвэрлэгээнд төрийн болон төрийн бус байгууллагууд идэвхтэй оролцов.Хогийн цэгт нийт 5тонн хог буулгаж хяналт тавьж ажиллав.



Буянт сум:

Буянт сумын Засаг даргын А/31 тоот Захирамжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор цэвэрлэгээг зохион байгуулж 5 байгууллагын 100 гаруй албан хаагч, 12 аж ахуйн нэгж 4 тонн орчим хог хаягдлыг цуглуулж тээвэрлэн нэгдсэн хогийн цэгт хүргэж устгалаа.



Цэнгэл сум:

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 08-р албан даалгавар болон Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргын 2023 оны 9-р сарын 04-ний өдрийн 275 тоот үүрэг даалгварыг биелүүлэх зорилгоор 2023 оны 10 сарын 13 ны өдөр сумын засаг даргын А/137 захирамжийн дагуу нийт 12 байгууллагын 120 гаруй албан хаагч нар сумын төвийн 3 км орчим гудамжинд эзэнгүй 3тн хог, Харгантын гол, Ховд голын эрэг, Байтас рашааны орчимын нийт 2 тн гаруй эзэнгүй ил задгай хаягдсан хогийг цэвэрлэж, гарсан хогийг сумын нэгдсэн хогийн цэгт хүргэж ажиллав.



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР